Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-өөс 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Тэшиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/121 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тэшиг сумын Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хэтийн хөгжлийг орон нутгийн нөөц боломж, онцлог, улс, аймгийн бодлого, чиглэлтэй уялдуулан боловсруулж, сумын ИТХ болон түүний Тэргүүлэгчид, төрийн гүйцэтгэх захиргааны байгууллага болох сумын Засаг даргыг бүрэн боловсрогдсон бодлогын зөвлөгөө дэмжлэгээр хангаж, тэдний үйл ажиллагааг явуулахад шуурхай үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтийг дэмжин, технологийн дэвшилд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлж, баялгийг бүтээн орлогыг нэмэгдүүлж, сэтгэл хангалуун, аз жаргалтай амьдралыг хамтдаа бүтээнэ
- Гэр бүлийг дэмжих, иргэн бүр эрүүл, боловсролтой, орлоготой нөхцөл бүрдүүлэхэд анхаарч ажилгүйдэл, ядуурлыг бууруулан иргэдийнхээ амьжиргааг сайжруулна
- Хууль, хяналтын болон үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлж, иргэний аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор эрсдэлд суурилсан удирдлага, шуурхай бэлэн байдлыг хангах

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тэшиг сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайланд 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 4030.3 сая төгрөгийн 2 хувь буюу 80.6 сая төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 42.62 сая, эцсийн үлдэгдэл 393.38 сая төгрөг болж, 350.76 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	42.57	393.31	350.74	100%
Арилжааны банкин дахь харилцах	0.05	0.07	0.02	0%
Бусад төсөл нөөцийн харилцах	0	0	0	0%
Дүн	42.62	393.38	350.76	100%
Үүнээс байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	41.0	236.5	195.5	60.1%
Төсөл/сан		0.0	0.0	0.0%
Төрийн сан	1.4	156.1	154.7	39.7%
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.2	0.7	0.6	0.2%
Дүн	42.62	393.38	350.76	100%

Эх сурвалж: Тэшиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 393.3 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.1 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө, хадгаламж дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 288.5 сая, эцсийн үлдэгдэл 247.2 сая төгрөг болж, 41.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон аг	0.59	0.08	-0.51	0.0%
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮ	0.51	0.36	-0.15	0.1%
Байгууллагаас авах авлага	14.68	23.79	9.11	9.6%
Хувь хүнээс авах авлага	272.72	222.96	-49.76	90.2%
Дүн	288.50	247.20	-41.30	100%
Үүнээс байгууллагын төрлөөр				
Засаг даргын тамгын газар	7.87	10.71	2.85	4.3%
Иргэдийн төлөөлөгчдийн хура	0.34	0.46	0.12	0.2%
Соёлын төв	0.02	0.00	-0.02	0.0%
Сум хөгжүүлэх сан	249.84	200.08	-49.76	80.9%
Сургууль	5.87	0.00	-5.87	0.0%
Улсын төсвийн хөрөнгө оруул	12.22	12.22	0.00	4.9%
Хүн эмнэлэг	4.78	0.91	-3.87	0.4%
Цэцэрлэг	0.51	16.50	15.99	6.7%
Тэшиг ус	7.07	6.31	-0.76	
Дүн	288.50	247.20	-41.30	97%

Эх сурвалж: Тэшиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 8.9 сая төгрөгийн дараах авлага байна.

Үүнд:

- ИТХ-ын 0.34, ЗДТГ-ын 7.9, хүн эмнэлгийн 0.69 сая төгрөгийн тодорхойгүй авлага байна. Эдгээр нь эзэн холбогдогч нь тодорхойгүйгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах төлөгдөхгүй байх үр дагавартай байна

Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэж, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Тухайлбал: Сургуулийн өмнөх боловсрол 16.5 сая төгрөг.
- Эм ханган нийлүүлдэг харилцагч байгууллагуудаас 2 аж ахуй нэгжтэй тооцоо нийлж бусад харилцсан байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны авлагын үлдэгдэл 1631.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдээдлийг хангахгүй байна. Тухайлбал: Эрүүл мэндийн төв 11.2 сая төгрөг

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэлгүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 358.15 сая, эцсийн үлдэгдэл 381.51 сая төгрөг болж, 23.35 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эдлэх хувь
Эм боох материал	24.66	9.43	-15.23	2.45%
Бэлэн бүтээгдэхүүн	5.19	37.86	32.67	9.83%
Бичиг хэргийн материал	7.49	10.30	2.81	2.67%
Аж ахуйн матераил	57.19	38.03	-19.16	9.87%
Сэлбэг хэрэгсэл	5.75	5.65	-0.10	1.47%
Түлш шатах тослох материал	1.62	7.12	5.50	1.85%
Барилгын засварын материал		0.00	0.00	0.00%
Хүнсний материал	31.4	11.97	-19.43	3.11%
Бусад хангамжийн материал	224.55	264.48	39.93	68.67%
Мал амьтад	0.3	0.30	0.00	0.08%
Дүн	358.15	385.14	26.99	100%
Үүнээс байгууллагын төрлөөр				
Засаг даргын тамгын газар	27.66	7.54	-20.12	1.96%
Иргэдийн төлөөлөгчдийн хура	1.28	3.78	2.50	0.98%
Соёлын төв	16.26	12.53	-3.73	3.25%
Сургууль	145.58	138.64	-6.94	36.00%
Хүн эмнэлэг	39.52	47.23	7.71	12.26%
Цэцэрлэг	91.31	126.92	35.60	32.95%
Эмийн эргэлтийн сан	20.58	0.00	-20.58	0.00%
Тэшиг ус	15.97	48.50	32.54	12.59%
Дүн	358.15	385.14	26.98	100%

Эх сурвалж: Тэшиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 26.98 сая төгрөгөөр өссөн нь “Тэшиг ус” ОНӨҮГ-ын худалдан авалтаас бага зарцуулалт хийсэнтэй холбоотой байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 424.36 сая, бусад эх үүсвэрээс 24.76 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 393.02 сая, дахин үнэлсэн болон акталсан 29.12 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 385.14 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✚ Бараа материалын ангиллыг буруу хөрөнгийн шинж чанартай зүйлийг бүртгэсэн УСНББОУС-12 ын дагуу зөв ангилж бүртгээгүй байна. Тухайлбал: СӨБ 10.6, ЕБС 0.9, ЗДТГ 6.3 тус тус сая төгрөг
- ✚ Жилийн эцсийн тооллогоорх бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнг зөрүүтэй, тооллогын анхан шатны баримтын хөтлөлт дутуу. Тухайлбал: ЭМТ, ЗДТГ

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 10839.4 сая, эцсийн үлдэгдэл 13023.2 сая төгрөг болж, 2183.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан - Дүнд эзлэх хувь	
Барилга байгууламж, орон сууц	7,644.21	10,356.99	2,712.79	196%
Хуримтлагдсан элэгдэл	-6,365.20	-6,475.23	-110.03	-123%
Авто-тээврийн хэрэгсэл	395.51	506.22	110.71	10%
Хуримтлагдсан элэгдэл	-241.72	-256.37	-14.65	-5%
Машин тоног төхөөрөмж/компьют	1,698.00	1,573.84	-124.16	30%
Хуримтлагдсан элэгдэл	-1,025.46	-903.07	122.39	-17%
Тавилга, аж ахуйн эд хогшил	251.05	280.98	29.94	5%
Хуримтлагдсан элэгдэл	-136.47	-110.8	25.67	-2%
Зам, гүүрийн байгууламж	0.00	0.00	0.00	0%
Хуримтлагдсан элэгдэл	0.00	0	0.00	0%
Батлан хамгаалах, цэргийн зориу	0.00	0	0.00	0%
Хуримтлагдсан элэгдэл	0.00	0	0.00	0%
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	0.00	0	0.00	0%
Бусад үндсэн хөрөнгө	54.18	61.21	7.03	1%
Хуримтлагдсан элэгдэл	-16.62	-6.51	10.11	0%
Дуусаагүй барилга, байгууламж	550.00	0	-550.00	0%
Ном	24.15	19.97	-4.18	0%
Программ хангамж	0.55	3.25	2.70	0%
Хуримтлагдсан элэгдэл	-0.14	-0.14	0.00	0%
Бусад биет бус хөрөнгө	221.80	221.80	0.00	4%
Хуримтлагдсан элэгдэл	-0.30	-0.30	0.00	0%
Дүн	3,053.53	5,271.86	2,218.33	100%
Засаг даргын тамгын газар	1,242.71	1,193.87	-48.84	22.6%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.96	2.58	1.62	0.0%
Соёлын төв	221.77	203.71	-18.07	3.9%
Сургууль	1,001.08	2,078.62	1,077.54	39.4%
Хүн эмнэлэг	301.17	419.29	118.13	8.0%
Цэцэрлэг	246.01	1,346.93	1,100.92	25.5%
Эмийн эргэлтийн сан	2.21	0.00	-2.21	0.0%
Тэшиг ус	37.63	26.85	-10.78	0.5%
Дүн	3,053.53	5,271.85	2,218.32	100%

Эх сурвалж: Тэшиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 66.92 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 550.42 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 4.05 сая, дахин үнэлсэн болон бусад 2527.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 579.7 сая, акталсан 197.82 сая, дахин үнэлсэн 186.75 төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✚ ЭМТ нь жилийн эцэст үндсэн хөрөнгийн тооллогыг хийгээгүй нь ТБОӨТХ-ийн 72, 73.2, НББ-ийн тухай хуулийн 20.2.6, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байх батламж мэдээгдлийг хангахгүй байна.
- ✚ Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүнгээс 366.5 мянган төгрөгөөр зөрүүтэйгээр “Тэшиг ус” ОНӨҮГ

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 141.9 сая, эцсийн үлдэгдэл .857.0 сая төгрөг болж, 715.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
Богино хугацаат зээлийн өглө	26.08	0	-26.08	0.0%
Ажилчидтай холбогдсон өглөг	0.21	0	-0.21	0.0%
Бараа үйлчилгээний зардлын	10.23	0	-10.23	0.0%
Байгууллагад төлөх өглөг	63.40	83.96	20.56	69.3%
Хувь хүмүүст төлөх өглөг	1.92	1.81	-0.11	1.5%
Татварын өглөг /ТӨҮГ/	40.10	35.29	-4.81	29.1%
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.00	0.04	0.04	0.0%
Дүн	141.93	121.09	-20.83	100.0%
Засаг даргын тамгын газар	0.21	0.00	-0.21	0.0%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.29	0.00	-0.29	0.0%
Хүн эмнэлэг	2.17	0.00	-2.17	0.0%
Цэцэрлэг	0.88	0.00	-0.88	0.0%
Эмийн эргэлтийн сан	37.11	0.00	-37.11	0.0%
Орон нутгийн хөгжлийн сан	3.89	3.89	0.00	3.2%
Тэшиг ус	97.38	117.20	19.83	96.8%
Дүн	141.93	121.09	-20.83	100%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
Засгийн газрын байгууллага, €	12.74	736.50	723.76	100.0%
Дүн	12.74	736.50	723.76	100%
Тэшиг ус	12.74	0	-12.74	0.0%
Засаг даргын тамгын газар	0	736.5	736.50	100.0%
Дүн	12.74	736.50	723.76	100%
НИЙТ ДҮН	154.67	857.59	702.93	100%

Эх сурвалж: Тэшиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл ОНХС болон “Тэшиг ус” ОНӨҮГ-ийн 121.09 сая төгрөг, урт хугацаат 736.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3588.2 сая, эцсийн үлдэгдэл 5437.2 сая төгрөг болж, 1849.1 сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,171.76	2,167.32	-4.43	39.8%
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	5.94		-5.94	0.0%
Хуримтлагдсан үр дүн	-162.21	1,700.76	1,538.55	31.3%
Өмнөх үеийн үр дүн	-64.91	-870.51	-805.60	-16.0%
Тайлант үеийн үр дүн	-97.30	2571.26	2,473.96	47.3%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,572.65	1,571.90	-0.75	28.9%
Дүн	3,588.15	5,439.98	1,851.83	1.00
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан				
Засаг даргын тамгын газар	200.66	200.66	0.00	3.7%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3.97	3.97	0.00	0.1%
Хүн эмнэлэг	244.53	244.53	0.00	4.5%
Сургууль	1,003.17	1,003.17	0.00	18.4%
Цэцэрлэг	180.25	180.25	0.00	3.3%
Соёлын төв	534.74	534.74	0.00	9.8%

Эмийн эргэлтийн сан	4.43		-4.43	0.0%
Өмч /хувийн/ /ТӨҮГ/			0.00	0.0%
Эмийн эргэлтийн сан	5.94		-5.94	0.0%
Хуримтлагдсан үр дүн			0.00	0.0%
Орон нутгийн ерөнхий орлого	1.43	156.1	154.70	2.9%
Орон нутгийн хөгжлийн сан	4.20	25.4	21.21	0.5%
Сум хөгжүүлэх сан	260.65	264.1	3.44	4.9%
Байгаль хамгаалах сан	22.13	143.2	121.10	2.6%
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	12.22	12.2	0.00	0.2%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	-1.69	2.85	4.85	0.1%
Эмийн эргэлтийн сан	-24.68		24.68	0.0%
Тэшиг ус	-49.31	-34.8	14.49	-0.6%
Сургууль	-148.75	916.0	1,064.73	16.8%
Засаг даргын тамгын газар	62.69	-739.7	-802.41	-13.6%
Соёлын төв	-296.96	-318.8	-21.82	-5.9%
Цэцэрлэг	50.94	1,204.3	1,153.40	22.1%
Хүн эмнэлэг	-55.06	69.8	124.89	1.3%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү			0.00	0.0%
Сургууль	298.12	298.12	0.00	5.5%
Засаг даргын тамгын газар	1,014.68	1014.68	0.00	18.7%
Соёлын төв	0.27	0.27	0.00	0.0%
Цэцэрлэг	105.75	105.75	0.00	1.9%
Хүн эмнэлэг	153.83	153.08	-0.75	2.8%
ДҮН	3,588.13	5,439.98	1,851.83	100%

Эх сурвалж: Тэшиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5440.29 сая төгрөг болж 1851.83 сая төгрөгөөр өссөн нь ЕБС болон СӨБ-ын байгууллагын өргөтгөл ашиглалтад орсноос шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 2167.32 сая төгрөг болж 4.43 сая төгрөгөөр буурсан, хувийн өмчийн дансны үлдэгдэл 0 сая төгрөг болж 5,94 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 2020 оны 57 дугаар тогтоолоор “Эмийн эргэлтийн сан”-г хасагдуулж бүртгэснээс шалтгаалж байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1571.9 сая төгрөг болж 0.75 сая төгрөгөөр буурсан нь Хүн эмнэлгийн хөрөнгийг дүн буурснаас шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй байна. .

Хуримтлагдсан үр дүн 1701.1 сая төгрөг болж 1863.27 сая төгрөгөөр өссөн нь тус сумын СӨБ, ЕБС-ийн өргөтгөлийн барилга ашиглалтад орсноос шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд орлогоор хүлээн зөвшөөрсөн уурын зуухын эргэн төлөлттэй холбоотой үүссэн өглөг, эмийн эргэлтийн санг хувьчилсантай холбоотой хасах, Хүн эмнэлгийн хөрөнгийн бүртгэлээс шалтгаалж, нийт 711.1 сая төгрөгийн алдааны залруулга байна.

3.5.10 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 201.5 сая төгрөгөөр баталж, 310.8 сая төгрөгийг бүрдүүлэн, 109.3 сая төгрөгөөр буюу 54 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +, хэмнэлт -	Хувь
1	Урсгал орлого	201.49	310.82	109.33	154%
11	ТАТВАРЫН ОРЛОГО	186.49	295.02	108.53	158%

110	Орлогын албан татвар	48.40	76.52	28.12	158%
1100	Хувь хүний орлогын албан татвар	48.40	76.52	28.12	158%
110002	Үйл ажиллагааны орлого	9.50	11.08	1.58	117%
110003	Хөрөнгийн орлого	13.90	14.27	0.37	103%
110008	Шууд бус орлого	25.00	51.17	26.17	205%
113	Хөрөнгийн албан татвар	5.79	5.96	0.17	103%
113002	Бууны албан татвар	5.79	5.96	0.17	103%
118	Бусад татвар, төлбөр, хураамж	132.30	212.54	80.24	161%
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	53.10	11.18	-41.92	21%
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3.10	4.58	1.48	148%
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2.00	2.28	0.28	114%
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.00	4.31	0.31	108%
118010	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	44.00	0	-44.00	0%
1181	Газрын төлбөр	25.00	25.14	0.14	101%
118101	Газрын төлбөр	25.00	25.14	0.14	101%
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	54.20	176.23	122.03	325%
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	52.00	51.70	-0.30	99%
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2.00	3.56	1.56	178%
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.20	0.20	0.00	100%
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0	120.76	120.76	#DIV/0!
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15.00	15.80	0.80	105%
120	Нийтлэг татварын бус орлого	15.00	15.80	0.80	105%
120002	Хүүгийн орлого	15.00	15.80	0.80	105%

Орлогын албан татвар 58.2 хувь, хөрөнгийн албан татвар 2.9, бусад татвар, төлбөр хураамж 60.7, татварын бус орлого 5.3 хувиар тус тус давж биелүүлсэн байна. Газар тариалан эрхлэгч иргэдийн 2019 оны орлого орсон, төлөвлөгдөөгүй улаан буудайн урамшуулал, “Эрдэнэс таван толгойн урамшуулал орсон, хадгаламж өссөн, бууны өмнөх оны татварыг төвлөрүүлсэн, төлөвлөгдөөгүй тэмдэгтийн хураамжийн төлбөр орсон, хууль бус ангийн орлогыг төвлөрүүлсэн, ойн самрын ургац их байснаас ААНБ-тай гэрээ хийн төлбөр төвлөрсөн, гүүрэн дээр пост гаргаснаас хогны орлогыг төвлөрүүлсэн, тендер дахин зарласнаас, татварын тайлангийн өмнөх оны хяналт шалгалтын биелэлтийг хангуулсан зэргээс орлого давж, модны зөвшөөрөлтэй ААНБ-аас айл өрхүүд их хэмжээний үзүүр ёзоор үнэгүй түлсэнтэй холбоотой ойгоос мод бэлтгэх төлбөр хураамж тасарчээ.

Аудитын илрүүлэлт:

Нийт дүнгээр сумын орлого 54.3 хувиар давж биелсэн ч бусад нийтлэг төлбөр хураамж 41.9 сая төгрөг буюу 79.0 хувиар, ойн нөөц ашигласны төлбөр 0.3 сая төгрөг буюу 0.6 хувиар тус тус тасарсан байна. Модны зөвшөөрөлтэй ААН, байгууллагаас айл өрхүүд их хэмжээний үзүүр ёзоор үнэгүй түлсэнтэй холбоотой ойгоос мод бэлтгэх төлбөр хураамж тасарчээ.

3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 191.67 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- + Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн байна. Тухайлбал: ЭМТ, ЗДТГ, БХС, ОНХС 76.9 сая төгрөг.
- + Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчин зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчин батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тухайлбал: Цэцэрлэг 8.2, Соёлын төв 2.8, ЕБС 8.0, ЗДТГ 2.0, ЭМТ 0.3 тус тус сая төгрөг
- + Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн нь НББ-ийн холбогдох стандарт, хууль тогтоомжийг мөрдөөгүй байна. Тухайлбал: Цэцэрлэг 71.5, ИТХ 10.6, МСТ 9.9, ЭМТ 62.6, ЗДТГ
- + Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулалт хийсэн байна. Тухайлбал: ОНХС 0.2
- + Тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас эм, эмийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна. Тухайлбал: ЭМТ 8.3
- + Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалтыг зөрчсөн байна. Тухайлбал: ЭМТ 1.3
- + Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолыг бүрэн хангаж ажиллаагүй байна. Тухайлбал: ЕБС 0.3,
- + Бараа материалын тооллогын дүн, тодруулгын дүн, үлдэгдэл дүн зөрүүтэй байна. Тухайлбал: ЭМТ 0.3,

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Тэшиг сумын ИТХ-ын 202 оны орон нутгийн төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар сумын ЗДТГ тайлант онд 0.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 0.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗДТГ	0.45	0.46	0.01	102
ДҮН	0.45	0.46	0.01	102
ЗДТГ-ын байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын, халаалт, цэвэр бохир усны төлбөр, түрээс	0.45	0.46	0.01	102
ДҮН	0.45	0.46	0.01	102

Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2020 оны төсвийг ИТХ-ын 2019 оны 04 дүгээр тогтоолоор орлогыг 3064.0 сая төгрөгөөр баталж ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны 02 тоот тогтоолоор 3189.4 буюу 125.4 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Тодотголоор ЗДТГ-т 51.4, ИТХ-д 2.1, СӨБ-д 39.9, БХС-д 51.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь урсгал засвар, тоног төхөөрөмж бэлтгэх, шинэ өргөтгөл ашиглалтад орсонтой холбоотой урсгал зардал нэмэгдсэн, ойн самрын ургацаас хамаарч ААН, байгууллагатай гэрээ хийн ойн нөөц ашигласны төлбөр, хураамж нэмэгдсэн, тэвчиж болох бусад зарим зардлыг 19.1 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3108.6 сая төгрөгийг урсгал зардалд, 80.8 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2008.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 944.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 100.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 70.8 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 41.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1855.1 сая төгрөг тусгай зориулалтын шилжүүлгээс, 815.4 сая төгрөг орон нутгийн төсвөөс, 19.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 90.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 222.2 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдэл 41.7 нийт 1188.9 сая төгрөгийн санхүүжилт буюу 186.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 222.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 151.4 сая төгрөгөөр давсан нь тайлант жилд ойн самрын ургац нэмэгдэж ААН, байгууллагатай гэрээ хийн төлбөр, хураамжийг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2807.6 мянган төгрөг буюу 88.03 хувьтай байгаа нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан, урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

- ✚ ЕБС, цэцэрлэгүүдийн халаалтын зардлыг 0.5 сар дутуу халаасан,
- ✚ Урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг хойшлуулсан,
- ✚ Боловсролын байгууллагын хоол хүнс, үдийн цай, дотуур байрны зардал хэмнэгдсэн,

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 2.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээнд 107.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 69.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 2.8 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 51.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 25.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.7 сая, нийт 81.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 5.1, Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 15.4, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 3.4, Бараа үйлчилгээний бусад зардалд 55.3, нэг удаагийн тэтгэмж

урамшуулалд 0.2 нийт 79.4 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 2.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож, 20.7 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: Хэтрэл хэмнэлтийн шалтгаан тайлбарыг эхний 3 улирал, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн төсөл, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 3 арга хэмжээний захирамжийг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0	0	0
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100
Нийт	3	-	3	-	-	-	100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага, 2 тусгай сан түүврээр хамрагдсан байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд БХС-г хамруулж үзлээ.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд ЕБС, “Тэшиг ус” ОНӨҮГ, “Зөрчилгүй”, ЭМТ-д “Сөрөг” дүгнэлтийг өгсөн байна.

Аудитаар нийт 1409.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 44.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1364.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлжээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

➤ Үр дүнгийн тайланд 22.6 сая төгрөгийн бараа материал акталсны зардлыг данс андуурч бүртгэсэн

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь хугацаа хоцроосон 15 мэдээлэл, хэтрэл хэмнэлтийн шалтгаан тайлбар эхний 3 улирал, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн төсөл, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 3 арга хэмжээний 20.7 сая, СХС-гийн 0.4 сая төгрөг, БХС-гийн 23.2 сая төгрөгийн захирамж, шийдвэрийг байршуулаагүй, мөн мөн харьяа байгууллагууд нийт 58, төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 15 мэдээллийг нэгдсэн системд хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1, 3.2, 4.1-д заасныг зөрчсөн, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 468.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8.5 сая төгрөгийн буруу бичилтийн алдааг аудитын явцад залруулж, 7.1 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 367.4 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 93.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 17 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийн жилийн дундуур хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө оруулсан өөрчлөлт, хийсэн зохицуулалтынхаа гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх, Харин төсвийн Төвлөрүүлэн захирагч харьяа байгууллагуудынхаа худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг цаг хугацаанд нь дүгнэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Нийт дүнгээр сумын орлого 54.3 хувиар давж биелсэн ч бусад нийтлэг төлбөр хураамж 41.9 сая төгрөг буюу 79.0 хувиар, ойн нөөц ашигласны төлбөр 0.3 сая төгрөг буюу 0.6 хувиар буюу модны зөвшөөрөлттэй ААН, байгууллагаас айл өрхүүд их хэмжээний үзүүр ёзоор үнэгүй түлсэнтэй холбоотой ойгоос мод бэлтгэх төлбөр хураамж тасарчээ.

4.1.2 Эрсдэл: Бодиттой төлөвлөөгүйгээс орлого давж эсвэл тасарснаас гүйцэтгэлд их хэмжээний өөрчлөлт орох, оновчтой бус зарцуулалт хийгдэх

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсөв боловсруулахдаа цаг үе, орчин нөхцөл буюу тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж батлуулах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн болно.

4.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.2.1 Илрүүлэлт: Тайлант онд өглөг 715.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлж өр, авлага үүсгэхгүй байх хуулийн шаардлагыг биелүүлээгүй байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

4.2.2 Эрсдэл: Өглөгийн насжилт нэмэгдэж, эзэнгүй болох.

Тэшиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн болно.

4.3 Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3.2 Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх

4.3.3 Өгсөн зөвлөмж: НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал.

4.4.1 Илрүүлэлт: Аудитаар нийт 468.9 сая төгрөгийн 47 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй, үр ашиггүй зарцуулагдах.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

А.СУВДАА